



**УАГ**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

## АУДИТЫГ ДУУСВАР БОЛГОСОН ТУХАЙ ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараахь хаягаар харилцана уу:**

Газрын захирал: С.Энхзаяа  
Утас: 261663

Аудитын менежер: Л.Одгэрэл  
Утас: 260512

Аудитор: С.Бат-Эрдэнэ  
Утас: 261628

Монгол Улсын Үндэсний Аудитын газар

Монгол Улс  
Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу  
Засгийн газрын IY байр

---

### АГУУЛГА

---

Оршил  
Санхүүгийн дотоод хяналт  
Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд  
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт  
Аудитын санал дүгнэлт

**Хавсралт 1:** Аудитын гэрчилгээ

**Хавсралт 2:** Менежментийн захидал

**Хавсралт 3:** Аудитийн дуусвар болсон тухай  
тайлан

**Хавсралт 4:** Аудитлагдсан санхүүгийн тайлан

## Оршил

Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитыг дуусвар болгосон тухай энэхүү тайланг тус газрын удирдлагад танилцуулж байна.

Менежментийн захидалд санхүүгийн зарим үйл ажиллагааг сайжруулах талаарх зөвлөмжийг тусгасан болно.

### Санхүүгийн дотоод хяналт

Соёл, спорт, аялал жуулчлалын яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар 2013 онд Монголын үндэсний музей, Сэлэнгийн долгио чуулга, Соёл урлаг хөгжүүлэх сан, Уран зургийн галерей, Улсын драмын эрдмийн театр, Соёл урлаг хөгжүүлэх сангийн зарим санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд хяналт шалгалтыг гүйцэтгэсэн байна. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд зөрчил арилгуулах хугацаатай үүрэг өгч, биелэлтийг хянасан байна.

ССАЖЯ-ны төв, аппарат болон, спортын төвлөрсөн арга хэмжээний зардлаас төсөл арга хэмжээг санхүүжүүлэхдээ мөнгөн хөрөнгийн данснаас шууд зардлаар бүртгэж байна.

### Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд

Аудитын явцад төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого, дансны нэгдсэн жагсаалт, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, түүвэр сорил хийхээр төлөвлөсөн байгууллагын дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангилалаар дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

### **НЭГ. Өмнөх түвшинд хийсэн аудитын дүнгийн талаар**

Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын Төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд тус яамны харъяа соёл, урлаг, спортын 28 байгууллага, мөн хөрөнгө оруулалт, спортын төвлөрсөн арга хэмжээ, ахмадын хороо зэрэг нийт 31 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Сайдын багцад нэгтгэгдсэн 31 байгууллагын 29 санхүүгийн тайланд аудит хийгдэж нийт төсвийн 1.5 хувь буюу 1,918.0 сая төгрөгийн төсөвтэй Уран зургийн галерей, Улсын филармони, Орхоны Олимп бэлтгэлийн төв зэрэг 3 байгууллага хязгаарлалттай санал дүгнэлт авч, бусад нь зөрчилгүй санал дүгнэлт авсан байна.

Аудитын явцад илэрсэн зөрчлийг дуусвар болгосон тайлан, менежментийн захидалд тусгасан байдлаар ангилан нэгтгэхэд дуусвар болгосон тайланд 531.2 сая төгрөг, менежментийн захидалд 498.0 сая төгрөгийн зөрчил дутагдлыг аудит хийлгэсэн байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж, баталгаажуулсан байна.

- Монголын үндэсний музей нь 44.9 сая төгрөгийн 1004 ш үзмэрийг алдсан боловч дээд байгууллагаас данснаас хасах шийдвэр гараагүй улмаас одоог хүртэл хөрөнгөнд бүртгэлтэй байна.
- Улсын дуурь бүжгийн эрдмийн театр үндсэн хөрөнгийн дансанд 84.3 сая төгрөгийн хувцас, тайз чимэглэлийн материал, Богд хааны ордон музей дохиолол хамгаалалтын 24.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг түүх соёлын дурсгалт зүйлийн дансанд орлогоор бүртгэсэн байна.
- Төрийн хэлний зөвлөл цалингийн тооцоололыг буруу хийснээс 2.3 сая төгрөгийн татварыг дутуу суутгасан байна.
- Уран зургийн галерей нь он дамжсан төлөгдөх хугацаа нь тодорхой бус 13.5 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Энэ шатанд хийсэн санхүүгийн аудитаар нийт үйлчлүүлэгч байгууллагын 2013 оны санхүүгийн тайланд 20 асуудлаар 310.9 сая төгрөгийн залруулга хийжээ.

### **Хоёр.Төсвийн ерөнхийлөн захирагчийн шатанд хийсэн аудитын дүнгийн талаар**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар ССАЖЯ-ны төв аппарат, Спортын төвлөрсөн арга хэмжээ, аялал жуулчлалын сан, Палентлоги, Архелогийн музейн шинэчлэл төслийн санхүүгийн баримтыг аудитын түүвэрт хамруулан шалгалаа.

УСНББОУС-01, Сангийн сайдын 2006 оны 32 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан, тэмдэглэл бэлтгэх аргачлал”-ыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс санхүүгийн нэгтгэсэн тайлангийн зарим үзүүлэлтүүдийг зөрүүтэй нэгтгэсэн байна.Үүнд:

#### **Мөнгөн хөрөнгийн талаар**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах” гэж заасныг зөрчиж санхүүгийн тайланд орлогыг дутуу тусгасан байна.Үүнд:ССАЖЯ-ны аппаратын тайланд нэмэлт санхүүжилтийн дансанд орсон 3.0 сая төгрөгийн орлогыг дутуу, Аялал жуулчлалын сангийн тайланд 0.4 сая төгрөгийн орлогыг илүү тайлагнасан байсныг аудитаар залруулах бичилтийг хийлгүүлсэн болно.

#### **Авлага, өглөгийн талаар**

Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын хэмжээгээр 2013 оны жилийн эцэст 317.7 сая төгрөгийн авлага, 299.4 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8–д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх ” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс ССАЖЯ-ны аппарат 2013 оны жилийн эцэст 2.2 сая төгрөгийн НДШ-ийн өглөг, Татварын хэлтэст 4.7 сая авлага үүсгэсэн, мөн ажилтнуудад 26.1 сая төгрөгийн урамшуулалт цалинг олгоходоо цалингаас суутгах 2.6 сая төгрөгийн НДШ-ийг суутган тооцож төсөвт төвлөрүүлээгүй байна.

### **Бараа материалын талаар**

ССАЖЯ спортын төвлөрсөн арга хэмжээ болон аялал жуулчлалын сангаас “Дөрвөн түшээ” ХХК-тай гэрээ байгуулж 15.0 сая төгрөгөөр 150 ш Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг хэвлүүлсэн боловч материалын орлого авч үлдэгдлийг тайлагнаагүй байсныг аудитын явцад залруулав.

### **Үндсэн хөрөнгийн талаар**

ССАЖЯ-ны аппарат 2012 оны жилийн эцэст “Интимэйт” ХХК-тай гэрээ байгуулан huandai sonata-7 маркын автомашин худалдан авахаар 35.0 сая төгрөгийг урьдчилж шилжүүлэн шууд зардалд бүртгэсэн байна. 2013 оны эхэнд уг автомашиныг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын дансаар бүртгэсэн байсныг аудитын явцад залруулав.

### **Түүх, соёлын дурсгал зүйлийн талаар**

Засгийн газрын 1994 оны 233 дугаар тогтоолоор баталсан Түүх соёлын дурсгалт зүйлийн тооллого явуулах журмын дагуу БСШУСайдын 2012 оны 74, 441 дүгээр тушаал, ССАЖСайдын 2012 оны А/57 дугаар тушаалаар Түүх соёлын дурсгалт зүйлийн тооллогыг явуулахаар комисс томилогдон ажилласан ба Засгийн газрын 2013 оны 38 дугаар тогтоолоор үзмэрт үнэлгээ хийж Засгийн газарт танилцуулах үүрэг өгсний дагуу үйл ажиллагаа явагдаж байгаа боловч 2013 оны жилийн эцсийн байдлаар тооллого, үнэлгээний нэгдсэн дүн гараагүй учраас аудитын явцад тулган баталгаажуулах боломжгүй байна. ССАЖСайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэтгэсэн тайланд 10.4 тэрбум төгрөгийн Түүх, соёлын дурсгалт зүйл бүртгэгдсэн байна.

### **Төсвийн гүйцэтгэлийн талаар**

Монгол Улсын 2013 оны төсвийн тодотголоор Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын багцын нийт төсвийг 121,747.5 сая төгрөгөөр баталсан байна. Батлагдсан төсвийн 35 хувь буюу 42,721.3 сая төгрөг нь хөрөнгө оруулалтын ,27 хувь буюу 32,887.1 сая төгрөг нь урсгал зардалд, 38 хувь буюу 46,139.1 сая төгрөг нь тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтэнд төсөвлөгдсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 104,300.1 сая төгрөгийн санхүүжилтийг авч тусгай шилжүүлгийн зардалд 46,139.1 сая төгрөгийг, хөрөнгө оруулалтын зардалд 27,413.9 сая төгрөгийг, урсгал зардалд 28,109.3 сая төгрөгийг зарцуулж, 2,637.8 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг аудитын тайланд нэгтгэсэн бөгөөд төсвийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгааныг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу Соёл, спорт, аялал жуулчлалын яамнаас албан ёсоор гаргуулж, баталгаажуулан ажлын баримтад хавсаргав.

### **Санхүүгийн тайлан тэнцлийн талаар**

ССАЖЯ-ны аппаратын тайланд нэмэлт санхүүжилтийн орлогоос 1.1 сая төгрөгийн бичиг хэргийн материал худалдан авсныг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор, 2.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авалтыг үндсэн бус үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн байна.

ССАЖЯ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 621.2 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, 380.6 сая төгрөгийн бүртгэлийн алдааг залруулсан байна.

### **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 10 зөвлөмж өгөгдсөн ба 8 зөвлөмжийг хэрэгжүүлж, 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Төсөл хөтөлбөр, арга хэмжээний зардлыг урьдчилж төлсөн төлбөрөөр бүртгэж, хэрэгжиж дууссаны дараа хүлээн авсан акт, баримт бичиг болон гүйцэтгэлийн тайланг авч, тооцоо нийлж актаар баталгаажуулсны дараа зардалд бүртгэж байх.
- Соёлын өв, музейн үзвэрүүдэд дахин үнэлгээ хийж, үнэ ханшийг зах зээлийн үнэд ойртуулах гэсэн зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

### **Аудитын санал дүгнэлт**

Бид Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн гэж үзэн **“Зөрчилгүй”** санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудиторт санал болгож байна.



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210040 Угсаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.25 № 689

талай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙД Ц.ОЮУНГЭРЭЛ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Соёл, спорт, аялал, жуулчлалын яамны удирдлага Төсвийн тухай хуульд заасны дагуу жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

070468



# СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦ

## 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

### Менежментийн захидал

#### Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс

Асуудал 1 Авлага, өглөг

#### Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс

Асуудал 2 Тайлан тэнцлийн талаар

Асуудал 3 Санхүүгийн аудитын дүгнэлтийн  
талаар

## **МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг хэрхэн сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандартын дагуу хийгддэг Үндэсний аудитын газрын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан юм.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Үндэсний аудитын газар энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан байгууллагын удирдлага болон санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.



### ҮАГ-ын ажиглалт

Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын хэмжээгээр 2013 оны жилийн эцэст 317.7 сая төгрөгийн авлага, 299.4 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8–д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх ” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс ССАЖЯ-ны аппарат 2013 оны жилийн эцэст 2.2 сая төгрөгийн НДШ-ийн өглөг, Татварын хэлтэст 4.7 сая авлага үүсгэсэн, мөн ажилтнуудад 26.1 сая төгрөгийн урамшуулалт цалинг олгоходоо 2.6 сая төгрөгийн НДШ-ийг суутган тооцож төсөвт төвлөрүүлээгүй байна.

### Эрсдэлүүд

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл тайлагнал нь холбогдох хууль, эрх зүйн акт, холбогдох стандартуудыг зөрчих.

### ҮАГ-ын зөвлөмжүүд

Татвар, нийгмийн даатгалын байгууллагатай тооцоо нийлж, өр авлагыг бууруулах.

Энэ зөвлөмжийн хэрэгжилтийг 2014 оны 09 дүгээр сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

### Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана

### ҮАГ-ын ажиглалт

ССАЖЯ-ны төв аппарат, спортын төвлөрсөн арга хэмжээний зардлаас төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхдээ мөнгөн хөрөнгийн данснаас тооцооны дансаар дамжуулалгүйгээр шууд зардлаар бүртгэж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэсэн заалт болон Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг мөрддөггүй байна.

### Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд зардлын гүйцэтгэл үнэн зөвөөр илэрхийлэгдэхгүй байх, авлага, өглөг дутуу тусгагдах.

### ҮАГ-ын зөвлөмжүүд

Харилцагч нэг бүрээр тооцооны данс үүсгэн өглөг, авлагын журналд ажил гүйлгээг бүрэн тусгаж байх.

Энэ зөвлөмжийн хэрэгжилтийг 2014 оны 09 дүгээр сарын 15-ны

### Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана

### ҮАГ-ын ажиглалт

ССАЖС-ын төсвийн багцын нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар Улсын Филармони, Уран зургийн галерей, Орхоны Олимпийн бэлтгэлийн төвийн санхүүгийн тайлан хязгаарлалттай, бусад нь зөрчилгүй дүгнэлт авсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 621.2 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, 380.6 сая төгрөгийн бүртгэлийн алдааг залруулсан байна.

### Эрсдэлүүд

Соёл, спорт аялал жуулчлалын сайдын төсвийн багцын нэгтгэсэн санхүүгийн тайланд зөрүүтэй тайлан нэгтгэгдэх.

### ҮАГ-ын зөвлөмжүүд

Аудитаар илэрсэн зөрчлийг арилгах талаар холбогдох арга хэмжээг авах, Төрийн аудитын тухай хуулийн 28.1-д заасны дагуу Хязгаарлалттай санал дүгнэлт авсан байгууллагуудын дарга, нягтлан бодогчдод холбогдох арга хэмжээг авч ҮАГ-т хариу ирүүлэх.

Энэ зөвлөмжийн хэрэгжилтийг 2014 оны 09 дүгээр сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

### Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана.

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант үе:2013/01/01-2013/12/31

төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
МӨНГӨН ХӨРӨНГӨ	260,462,983.10	1,499,032,977.69
Кассанд байгаа бэлэн мөнгө	27,552,140.71	1,902,027.76
Төгрөг\ ЖМС	27,552,140.71	1,902,027.76
Банкинд байгаа бэлэн мөнгө	232,910,842.39	1,497,130,949.93
Төгрөг	232,910,842.39	1,497,130,949.93
Улсын төсвийн харилцах	1,607,281.18	
Төсөвт байгууллын харилцах (Төрийн сан)	7,540,608.33	
Төсөвт байгууллагын харилцах	205,514,733.39	749,514,325.44
Төсөвт байгууллын харилцах (Арилжааны банк)	18,248,219.49	848,107.85
Нэмэлт санхүүжилтийн харилцах		746,768,516.64
<b>АВЛАГА</b>	<b>1,628,953,153.63</b>	<b>317,684,407.33</b>
Ажиллагчидтай холбогдсон авлага	44,832,356.35	15,394,126.39
Төлбөртэй үйлчилгээний авлага	18,595,335.11	18,632,957.98
Татаас, санхүүжилт, (бүтээгдэхүүн нийлүүлэлтийн) авлага	27,993,594.00	
Бусад авлага	1,537,531,868.17	283,657,322.96
Байгууллагаас авах авлага	1,415,135,165.84	242,284,688.23
Гэрэл цахилгааны авлага	505,960.00	1,337,855.00
Түлш халаалтын авлага	5,202,016.00	
Дотоод албан томилолтын авлага	1,031,455.00	13,032,890.00
Урсгал засварын авлага	79,096.00	
Бусад зардлын тооцооны авлага	1,408,316,638.84	227,913,943.23
Хувь хүмүүсээс авах авлага	122,396,702.33	41,372,634.73
УРЬДЧИЛГАА	5,832,671.00	173,438,982.75
Бусад урьдчилгаа	5,832,671.00	173,438,982.75
Урьдчилгаа тооцоо		10,242,600.00
Томилолтын урьдчилгаа		10,242,600.00
Урьдчилж гарсан зардал	5,832,671.00	163,196,382.75
Урьдчилж төлсөн зардал	5,832,671.00	163,196,382.75
БАРАА МАТЕРИАЛ	6,704,202,765.40	2,396,345,366.42
Түүхий эд материал	1,029,718,183.52	388,138,478.30
Тусгай зориулалттай материал	794,282,808.33	340,898,284.70
Эм боох материал	90,195,724.14	4,767,720.00
Бэлэн бүтээгдэхүүн	145,239,651.05	42,472,473.60
Хангамжийн материал	5,347,254,544.06	1,950,849,797.68
Бичиг хэргийн материал	242,247,438.00	83,188,253.00

Аж ахуйн материал	2,558,380,611.83	765,667,807.95
Сэлбэг хэрэгсэл	47,102,630.20	18,589,150.00
Түлш, шатах тослох материал	188,040,096.43	3,959,293.59
Барилгын засварын материал	111,891,602.20	23,769,166.00
Хүнсний материал	5,259,099.94	
Баглаа боодол	10,715,047.00	
Бусад бараа материал	2,183,618,018.46	1,055,676,127.14
Мал амьтад	7,107,580.00	
Бусад	320,122,457.82	57,357,090.44
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	8,599,451,573.13	4,386,501,734.19
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	228,609,277,265.06	60,184,748,088.98
Биет хөрөнгө	228,464,924,313.66	60,068,200,002.11
Барилга, байгууламж, орон сууц	163,976,306,701.39	39,967,430,400.17
Барилга, байгууламж орон сууц - Анхны өртөг	263,963,610,181.93	57,164,331,538.40
Барилга, байгууламж орон сууц - Хуримтлагдсан элэгдэл	(99,987,303,480.54)	(17,196,901,138.23)
Авто-тээврийн хэрэгсэл	3,112,668,814.25	979,361,021.22
Авто-тээврийн хэрэгсэл анхны өртөг - Анхны өртөг	4,399,076,822.78	1,436,007,910.78
Авто-тээврийн хэрэгсэл - Хуримтлагдсан элэгдэл	(1,286,408,008.53)	(456,646,889.56)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	8,595,539,602.03	4,724,466,871.98
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг	18,722,658,729.47	8,447,018,086.41
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Хуримтлагдсан элэгдэл	(10,127,119,127.44)	(3,722,551,214.43)
Тавилга, аж ахуйн эд хогшил	6,760,501,116.91	1,605,782,072.41
Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг	11,200,277,849.23	2,798,193,015.15
Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	(4,439,776,732.32)	(1,192,410,942.74)
Зам, гүүрийн байгууламж	110,022,512.95	52,572,235.46
Зам, гүүрийн байгууламж - Анхны өртөг	182,083,604.06	122,149,478.06
Зам, гүүрийн байгууламж - Хуримтлагдсан элэгдэл	(72,061,091.11)	(69,577,242.60)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	10,186,568,020.09	10,452,635,717.26
Бусад үндсэн хөрөнгө	9,650,706,280.04	2,285,951,683.61
Бусад үндсэн хөрөнгө - Анхны өртөг	7,093,052,843.95	2,254,094,937.02
Бусад үндсэн хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(2,540,392,302.86)	(1,139,022,339.19)
Номын фонд	5,098,045,738.95	1,170,879,085.78
Дуусаагүй барилга, байгууламж	26,072,611,266.00	
Биет бус хөрөнгө	144,352,951.40	116,548,086.87
Програм хангамж	93,521,780.54	62,992,103.63
Програм хангамж - Анхны өртөг	235,145,547.00	96,364,495.00
Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл	(141,623,766.46)	(33,372,391.37)
Бусад биет бус хөрөнгө	50,831,170.86	53,555,983.24

Бусад биет бус хөрөнгө - Анхны өртөг	66,122,780.00	55,776,000.00
Бусад биет бус хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(15,291,609.14)	(2,220,016.76)
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>237,208,728,838.19</b>	<b>64,571,249,823.17</b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		
өглөг	488,899,177.96	299,353,549.48
Ажилчидтай холбогдсон тооцоо	44,157,911.12	20,667,676.46
Цалингийн өглөг	5,004,236.51	247,635.00
НДШ-ийн өглөг	19,267,544.10	10,868,906.71
ХАОАТ-ын өглөг	12,992,120.13	9,551,134.75
ҮЭ-ийн өглөг	6,894,010.38	
Бараа үйлчилгээний зардлын тооцоо	179,337,707.84	92,719,419.76
Гэрэл цахилгааны тооцоо	58,028,147.00	83,183,441.00
Түлш халаалтын тооцоо	106,414,327.66	
Шуудан холбооны тооцоо	7,891.70	70,827.00
Цэвэр, бохир усны тооцоо	868,763.00	3,463,574.76
Тээвэр шатахууны тооцоо	674,436.00	
Байрны засварын тооцоо		6,000,000.00
Бусад зардлын тооцоо	13,344,142.48	1,577.00
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн тооцоо	3,317,500.00	
Бусад өглөг	262,086,059.00	185,966,453.26
Байгууллагад төлөх өглөг	206,734,908.80	184,888,283.26
Хувь хүмүүст төлөх өглөг	55,351,150.20	1,078,170.00
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>488,899,177.96</b>	<b>299,353,549.48</b>
Засгийн газрын хувь оролцоо	236,721,247,360.23	64,271,896,273.69
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ Орон нутгийн сан	202,999,665,839.22	57,459,203,335.13
Хуримтлагдсан үр дүн	(27,022,472,578.70)	2,201,526,777.32
өмнөх үеийн үр дүн	(27,022,472,578.70)	(3,817,686,979.81)
Тайлант үеийн үр дүн		6,019,213,757.13
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	60,744,054,099.71	4,611,166,161.24
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>236,721,247,360.23</b>	<b>64,271,896,273.69</b>
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>237,210,146,538.19</b>	<b>64,571,249,823.17</b>

## АУДИТ ХИЙГДСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант үе:2013/01/01-2013/12/31

төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,850,116,282.52	122,250,892,674.55
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	4,850,116,282.52	122,250,892,674.55
Улсын төвлөрсөн төсвөөс		120,787,153,355.55
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		29,975,036,509.26
Хөрөнгийн		28,185,977,896.00
Сангийн сайдын багцаас санхүүжүүлсэн		12,547,597,031.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		3,939,437,119.29
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж		685,373,579.83
Төсвийн жилийн явцад УИХаас соёрхон баталсан ЗГ хоорондын гэрээ болон ОУбайгууллага		30,546,663.47
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс		533,400,732.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид өгсөн		2,110,831,630.83
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		104,129,909.21
Төсвийн урамшуулал		475,154,603.95
Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт		46,139,104,800.00
Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	1,174,495,242.00	
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,174,495,242.00	
Төсөвт байгууллагаас	1,071,438,135.52	1,237,154,671.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	602,000,000.00	
өр барагдуулах санхүүжилтийн орлого	2,204,672.52	
ТЕЗ-аас олгосон санхүүжилт	467,233,463.00	1,237,154,671.00
Нийгмийн даатгалын сангаас	2,073,102.00	6,584,648.00
НДС-ийн шилжүүлэг	2,073,102.00	6,584,648.00
Бусад Засгийн газрын тусгай зориулалтын сангаас санхүүжих	2,602,109,803.00	220,000,000.00
Соёл урлаг хөгжүүлэх санд олгох татаас	2,594,391,003.00	220,000,000.00
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	7,718,800.00	
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,528,124,193.19	8,956,724,708.70
Бараа, үйлчилгээний борлуулалт	6,527,712,775.19	2,942,014,150.02
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	3,877,152,635.32	2,940,824,150.02
үндсэн үйл ажиллагааны орлого	2,646,241,777.55	2,228,018,487.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	643,999,715.83	231,032,458.41
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	586,911,141.94	481,773,204.61
Захиргааны хураамж	2,650,560,139.87	1,190,000.00

Шүүхийн шийдвэрийн төлбөр	2,650,560,139.87	1,190,000.00
Торгууль, шимтгэл	411,418.00	
Татварын бус бусад орлого		6,014,710,558.68
Хөрөнгийн орлого		6,014,710,558.68
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	11,378,240,475.71	131,207,617,383.25
АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ	38,309,959,515.99	12,450,432,766.40
Үндсэн болон нэмэгдэл цалин	34,541,737,916.10	11,210,820,428.43
Үндсэн цалин	33,230,449,370.01	9,292,739,490.27
Гэрээт ажилчдын цалин	1,184,870,609.80	1,172,565,942.26
Унаа хоолны хөнгөлөлт	93,504,813.99	734,885,771.90
Бусад нэмэгдлүүд	32,913,122.30	10,629,224.00
Үр дүнгийн урамшуулал	16,748,236.00	10,629,224.00
Унаа, болон бусад нөхөн олговор	16,164,886.30	
Нийгмийн хамгааллын шимтгэл	3,768,221,599.89	1,239,612,337.97
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	3,198,496,055.42	1,024,155,422.08
Тэтгэврийн даатгалын шимтгэл	2,605,834,095.89	799,314,375.47
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	163,462,986.06	90,165,227.26
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	282,408,512.80	109,014,219.53
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	144,269,882.67	25,661,599.82
Бүтцийн өөрчлөлтийн цалингийн НДШ	2,520,578.00	
Эрүүл мэндийн даатгалын хураамж	569,725,544.47	215,456,915.89
УРСГАЛ ЗАРДАЛ	44,277,445,685.59	34,182,351,061.31
Бараа үйлчилгээний урсгал зардал	33,166,305,453.34	15,029,033,470.70
Тогтмол зардал	9,646,766,413.72	766,845,299.76
Гэрэл цахилгаан	885,005,452.46	353,541,294.52
Түлш, халаалт	8,425,773,643.74	325,608,502.91
Цэвэр, бохир ус	335,987,317.52	87,695,502.33
үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал	129,096,764.76	157,573,477.94
Хоол	129,091,764.76	157,525,477.94
Эм, вакцин	5,000.00	48,000.00
Бусад бараа үйлчилгээний зардал	23,390,442,274.86	14,104,614,693.00
Бичиг хэргийн зардал	224,304,328.25	129,186,582.08
Тээвэр, шатахуун	498,290,061.12	212,762,489.65
Шуудан, харилцаа холбоо	165,996,980.94	64,266,831.64
Дотоод албан томилолт	344,283,731.21	267,056,982.79
Гадаад албан томилолт	132,104,907.14	134,301,298.60
Ном, хэвлэл захиалах, худалдан авах	64,248,993.67	32,125,961.75
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага	36,488,071.00	11,719,360.00
Сургалт семинарын зардал	89,085,469.00	26,023,658.78



Эрдэм шинжилгээний ажил хийх	47,250,201.15	26,364,161.00
Жижиг эд хогшил худалдан авах	304,736,740.42	68,517,373.37
Жижиг эд хогшил худалдан авах \Багаж хэрэгсэл\	25,084,519.00	37,462,781.04
Жижиг эд хогшил худалдан авах \Тавилга\	177,879,403.89	1,288,000.00
Жижиг эд хогшил худалдан авах \Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл\	454,700.00	
Жижиг эд хогшил худалдан авах \Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс\	100,254,120.53	29,691,242.33
Жижиг эд хогшил худалдан авах \Програм хангамж\	1,063,997.00	75,350.00
Нормын болон дүрэмт хувцас, зөөлөн эдлэл	93,152,254.59	24,888,870.00
Төлбөр хураамж, жижиг татварууд	495,504,699.50	383,796,040.24
Харуул, хамгаалалтын зардал	117,687,720.99	96,461,870.00
Банкны үйлчилгээний хураамж	1,022,631.00	108,200.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,599,466,577.06	1,878,375,044.55
ТӨГАҮ \өмгөөлөл, хуулийн зөвлөх үйлчилгээний хөлс\	19,900,000.00	
ТӨГАҮ \Уран бүтээл хийлгэх, бэлтгүүлэх\	830,024,969.09	789,864,214.89
ТӨГАҮ \Эрдэм, шинжилгээ, судалгааны ажлын хөлс\	11,017,335.00	8,251,630.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	689,379,607.64	993,937,216.77
ТӨГАҮ \Ажил олгогчийн урамшуулал???\		1,253,533.00
ТӨГАҮ \Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс \	1,184,800.00	30,412,905.89
ТӨГАҮ \Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс (гадаад) \	6,174,714.00	12,510,030.00
ТӨГАҮ \Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж \	3,769,792.33	
ТӨГАҮ \Аудит, зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс (дотоод) \	12,290,265.00	800,000.00
ТӨГАҮ \Тээврийн хэрэгслийн даатгал\	5,922,140.00	2,239,414.00
ТӨГАҮ \Харуул, хамгаалалтын хөлс \	19,624,954.00	38,906,100.00
